

АВТО ХИМИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

Кэй эйч апартамент 6в-2 тоот,
стадион оргил-1 Чингисийн өргөн
чөлөө, Хан-Уул дүүрэг 15- хороо
Улаанбаатар

70117940
info@wuerthmongolia.com
www.wuerth.de

ДЭЛХИЙ ДАЯАР 84 ОРОНД
400 гаруй салбар компани



АВТО ХИМИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА



Вюрт групп нь дэлхийн 84 оронд 400 гаруй салбар компанитайгаар үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд салбартаа тэргүүлэгч юм. Одоогоор 70,000 орчим ажилчидтай ба тэдгээрээс 31,000 орчим нь борлуулагч менежерүүд байдаг. Вюрт групп нь 125,000 гаруй нэр төрлийн барааг үйлдвэрлэн худалдаалдаг бөгөөд эдгээрт жижиг шруппнээс эхлэн том оврын цахилгаан багаж, химийн бодис мөн хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл гэх мэт багтдаг. Энэхүү танилцуулга нь таны автомашинд хэрэглэгдэх химийн бүтээгдэхүүнүүдийг танилцуулах бөгөөд эдгээр нь Герман улсад үйлдвэрлэгдсэн чанарын өндөр стандарттай бүтээгдэхүүнүүд юм.



ХОЛИМОГЫН ХААЛТ / ЦАХИЛГААН

Холимогын хаалт цэвэрлэгч

Үр дүн

Агаарын хоолой болон хавхлагын бохирдлыг цэвэрлэж түүний оновчтой ажиллагааг дэмжинэ.


Хэрэглэх заавар:

Хөдөлгүүрийг унтрааж хавхлагыг цэвэрлээд 2 оос 3 минут хүлээнэ.

Хөдөлгүүрийг ажиллуулж хавхлага руу цацаж хэрэглэх бөгөөд бага багаар машины хөдөлгүүрийн эргэлтийг ихэсгэнэ.



Код : 5861113500



Цахилгааны холболт цэвэрлэгч

Үр дүн

Бага вольтод ажилладаг цахилгааны эд анги болон холболтуудыг цэвэрлэж, богино холбоос үүсэхээс сэргийлнэ. Тусгайлан автомашины цахилгааны эд ангиудыг цэвэрлэхэд нэн тохиромжтой.



Код : 0890100

РАДИАТОР

Радиатор нөхөгч

Үр дүн

Нарийн цууралт болон жижиг нүхийг урт хугацаанд нөхөж битүүмжилнэ.

Хөдөлгүүр гэмтэхээс сэргийлнэ.

Радиаторт ямар нэгэн гэмтэл өгөхгүй.

Резин болон хуванцар эд ангиудад гэмтэл өгөхгүй.

Хэрэглэх заавар:

Хэрэглэхээс өмнө сайтар сэгсрээд. Нөхөгчийг халуун радиаторын шингэнд нэмнэ. Хөдөлгүүрийг дор хаяж 10 минут ажиллуулна. 300мл нөхөгчийг 10 литр радиаторын шингэнд нэмж хэрэглэхэд тохиромжтой.



Код .: 5861501300

Радиатор цэвэрлэгч

Үр дүн

Хөргөлтийн системийн бохирдлыг цэвэрлэснээр түүний ажиллагааг дэмжинэ. Шинэ хөргөлтийн шингэн хурдан бохирдохгүй. Радиатор үйлдвэрлэхэд хэрэглэгддэг бүх материалуудад ямар нэгэн гэмтэл өгөхгүй.

Хэрэглэх заавар:

250мл цэвэрлэгчийг 10 литр хөргөлтийн шингэнд хэрэглэнэ.



Код .: 5861510250



ДИЗЕЛЬ

Дизель форсунк цэвэрлэгч

Үр дүн

Форсунк цэвэрлэгч нь таны автомашины түлшний банкнаас шаталтын хөндий хүртэлх түлш дамжих бүх эд ангиудыг цэвэрлэнэ. Түлшний насос, гуурс болон шланк зэрэг эд ангиудын бохирдлыг арилгаж дахин бохирдохоос сэргийлнэ.

Хэрэглэх заавар:

300 мл цэвэрлэгчийг 30-50 литр түлшинд нэмж хэрэглэнэ.



Код .: 5861011300

Дизель шаталтын хөндий цэвэрлэгч

Үр дүн

Автомашины форсунк болон шаталтын хөндийг өндөр төвшинд цэвэрлэснээр түлш зарцуулалт болон хорт утаа ялгаруулалтыг багасгана. Моторыг бүрэн хүчээрээ ажиллах боломжийг бүрдүүлнэ.

Хэрэглэх заавар:

Түлшинд нэмж хэрэглэх ба түлшний чанараас хамааран их багыг тохируулна. Хэрэглэсний дараа түлшний шүүрийг соливол илүү үр дүнтэй.



Код .: 5861012300

Дизель цетан өсгөгч

Үр дүн

Түлшний чанарыг сайжруулснаар автомашинаас ялгарах хорт утааг багасгана мөн хүйтэнд асах чадварыг нэмэгдүүлнэ. Хөдөлгүүрийн дууг багасгана. Түлш сайжирснаар бүрэн шаталт явагдах учир автомашины түлш зарцуулалт багасна.

Хэрэглэх заавар:

Түлшинд нэмж хэрэглэх ба түлшний чанараас хамааран их багыг тохируулна.



Код .: 5861005300



ДИЗЕЛЬ


Дизель автомашины нүүрсэн шүүр цэвэрлэгч

Үр дүн

Нүүрсэн шүүр энд хуримтлагдсан бохирдлыг уусгаж цэвэрлэнэ. Ингэснээр таны машины нүүрсэн шүүр бүрэн хүчээрээ ажиллах боломжтой болно. Мөн энэхүү бүтээгдэхүүнээр EGR хавхлагыг ч цэвэрлэж болно.

Хэрэглэх заавар:

Шүүр энд суурилах мэдрэгчийг тайлж аваад цэвэрлэгчийн гуурсыг хийж сайтар шахаж хэрэглэнэ. Хэрэглэсний дараа автомашины компьютерын санах ойг устгах хэрэгтэй. 1 сав цэвэрлэгч нь 1 шүүр цэвэрлэхэд тохиромжтой.



Код .: 5861014500


Дизель агаарын систем цэвэрлэгч

Үр дүн

Автомашины агаарын системийн хөө тортог бохирдлыг бүрэн цэвэрлэнэ. Хөдөлгүүрийн ажиллагааг сайжруулж хүчийг нэмэгдүүлнэ.

Хэрэглэх заавар:

Хэрэглэхээс өмнө хөдөлгүүрийг 20минут орчим ажиллуулна. Хэрэглэх явцад хөдөлгүүрийг 2000rpm эргэлтгүйгээр тогтмол ажиллуулна . 3 секундйн туршид агаарын хоолойд цацаж 10 секунд хүлээж энэ маягаар дуустал нь хэрэглэнэ.



Код .: 5861013300


Дизель өвлийн нэмэлт

Үр дүн

Дизелийн суваг болон насосыг бөглөрхөөс сэргийлнэ. Дизелийн шүүгдэх чадварыг нэмэгдүүлнэ. Хүйтэнд хөдөлгүүрийн асах хугацааг багасгана.

Хэрэглэх заавар:

Түлшинд нэмж хэрэглэх ба 150мл нэмэлтийг 70 литр түлшинд хэрэглэнэ.



Код .: 5861002001



ХӨДӨЛГҮҮР БОЛОН ХУРДНЫ ХАЙРЦАГ


Хөдөлгүүрийн тос сайжруулагч

Үр дүн

Хөдөлгүүрийн тосыг сайжруулснаар хөдөлгүүр хэт халахаас сэргийлнэ. Хөдөлгүүрийн тосны сувгуудын бохирдлыг арилгаж элэгдлийг удаашруулна.

Хэрэглэх заавар:

300 мл тос сайжруулагч нь 4,5 литр тосонд нэмж хэрэглэнэ.



Код .: 5861300300


Автомат хурдны хайрцагны ажиллагаа сайжруулагч

Үр дүн

Хурдны хайрцагны тосны тослох чадварыг нэмэгдүүлж эд ангиудын элэгдлийг багасгана. Тосыг зун хөөсрөх, өвөл царцахаас сэргийлж тохирох температурт байлгана. Хүйтэнд араа солигдолтыг сайжруулна.

Хэрэглэх заавар:

Хурдны хайрцагны тосоо солихдоо ажиллагаа сайжруулагчийг нэмж хэрэглэнэ.





ХӨДӨЛГҮҮР


Хөдөлгүүрийн тос тогтоогч

Үр дүн

Хөдөлгүүрийн жийргээр хөлөрч гоожих тосыг зогсооно. Бензин болон дизель хөдөлгүүрийн тос зарцуулалтыг багасгана.

Хэрэглэх заавар:

300 мл тос тогтоогчийг 5 литр хөдөлгүүрийн тосонд нэмж хэрэглэнэ.



Код .: 5861311150

Хөдөлгүүрийн утаа зогсоогч

Үр дүн

Тосны наалдамхай чанарыг тогтворжуулснаар тосны ширгэлтийг багасгаж, автомашины хөх утаа хаялтыг зогсооно

Хэрэглэх заавар:

300 мл утаа зогсоогч нь 5литр тосонд тохиромжтой. Хэрэглэсний дараа хөдөлгүүрийг халтал ажиллуулна.



Код .: 5861301300

Хөдөлгүүр цэвэрлэгч

Үр дүн

Хөдөлгүүрийн тосны чанарыг сайжруулж хөдөлгүүрийн бүрэн ажиллагааг дэмжинэ.


Хорт утаа ялгаруулалтыг багасгана.

Хөдөлгүүрийн элэгдлийг удаашруулна.

Хэрэглэх заавар:

Минерал болон синтетик тос хэрэглэдэг хөдөлгүүрт тохиромжтой. 400млтэй цэвэрлэгчийг 4-5литр тосонд нэмж хэрэглэнэ.

Хөдөлгүүрийг халуун байх үед цэвэрлэгчийг нэмж 10 минут хөдөлгүүрийг ажиллуулна. Дараагаар нь муу тосыг асгаж тосны шүүрийг солино.



Код .: 5861310400

БЕНЗИН


Бензин форсунк цэвэрлэгч

Үр дүн

Бензин систем (банкнаас шаталтын хөндий хүртэл)-ийн бохирдлыг цэвэрлэж системд конденсац үүсэхээс сэргийлнэ. Ингэснээр таны автомашины бензин зарцуулалтыг багасгаж системийн элэгдлийг багасгана.

Хэрэглэх заавар:

300 мл цэвэрлэгчийг 50-60 литр бензинд нэмж хэрэглэнэ.



Код .: 5861111300

Октан дээшлүүлэгч

Үр дүн

Хөдөлгүүрийн хүчийг нэмж элэгдлийг багасгана.

Шаталтын хөндийн бохирдолт багасна.


Октаны тоог нэмнэ.

Хорт утааг багасгана.

Бензин зарцуулалтыг багасгана.

Хэрэглэх заавар:

300мл октан өсгөгчийг 50-60 литр бензинд нэмж хэрэглэнэ



Код .: 5861103300


Бензин агаарын систем цэвэрлэгч

Үр дүн

Бензин форсунк, шаталтын хөндий болон агаарын урсгалын хөндийг цэвэрлэж хөдөлгүүрийг бүрэн хүчээр ажиллуулж, бензин зарцуулалтыг багасгана.

Хэрэглэх заавар:

Агаарын хоолойг тохиромжтой холболтоор салгаж агаарын хавхлага руу цацна. Хөдөлгүүрийг асааж эргэлтийг 2000rpm орчимд жигд ажиллуулах явцад үлдсэн цэвэрлэгчийг цацна. 4 цилиндртэй автомашинд 1 сав 6 цилиндртэй автомашинд 2 савыг хэрэглэнэ.



Код .: 5861112300

FIA **ASIA-PACIFIC** **RALLY** **CHAMPIONSHIP**



 **WÜRTH**